



**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2011 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 584

Улаанбаатар хот

**Маягт, заавар батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн 27.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын мэдээ", ТТ-11/1/ маягт, зааврыг 1 дүгээр, "Аж ахуйн нэгж, байгууллагаас хувь хүнд олгосон албан татвар суутгагдаагүй орлогын дэлгэрэнгүй мэдээ", ТТ-12/2/ маягт, зааврыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан маягтуудын дагуу программ зохиох ажлыг 2011 оны 11 дүгээр сард багтаан дуусгаж Татварын албаны вэб сайтад байрлуулахыг Мэдээлэл, технологийн төв /Н.Нямдорж/-д үүрэг болгосугай.

3.Маягтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын төсвийн орлого, хяналтын газар, нийслэл, аймаг, дүүргийн татварын хэлтсийн дарга нарт даалгасугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татвар хураалтын хэлтэс /С.Туул/, Татвар төлөгчтэй харилцах хэлтэс /Д.Баяраа/, Мэдээлэл, технологийн төв /Н.Нямдорж/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Б.БАТТӨМӨР